



**САНГИЙН ЯАМ**

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2015  
ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ, 2016-2017 ОНЫ ТӨСВИЙН  
ТӨСӨӨЛӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ**

**Улаанбаатар хот  
2014 оны 07 дугаар сарын 04**

## Агуулга

1.	Үндсэн мэдээлэл .....	3
1.1	Төсөв боловсруулахтай холбогдолтой хууль, эрх зүйн актууд .....	3
1.2	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд .....	3
2.	Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын чиглэлүүд.....	4
3.	Монгол Улсын нэгдсэн төсвийн хязгаар .....	4
3.1.	Улсын болон Нийгмийн даатгалын сангийн төсвийн хязгаар .....	4
3.2	Орон нутгийн төсвийн хүрээ, хязгаар.....	5
3.3	Хүний хөгжил сангийн төсвийн хязгаар.....	6
4.	Монгол Улсын 2015 оны төсвийн төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар..	7
4.1	Төсвийн орлого .....	7
4.2	Улсын болон НДС-ийн төсвийн зарлага.....	7
4.3.1	Төв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгүүд .....	10
4.3.2.	Тусгай зориулалтын шилжүүлгийн хуваарилалтын санал бэлтгэх.....	10
5.	Бусад нэмэлт мэдээллүүд .....	10
5.1	Төсвийн ангилал ашиглах .....	10
5.2	Бусад.....	11
5.3	Төсвийн санал хүлээн авч хянах хугацаа.....	11
6.	Төсвийн төсөл бэлтгэх маягтууд, тэдгээрийн заавар .....	12
6.1	Үндсэн маягтууд .....	12
6.2	Нэмэлт маягтууд .....	13
6.3	Хавсралт маягтууд .....	13

## 1. Үндсэн мэдээлэл

### 1.1 Төсөв боловсруулахтай холбогдолтой хууль, эрх зүйн актууд

Монгол Улсын 2015 оны төсвийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан дараах эрх зүйн актыг үндэслэн боловсруулна. Үүнд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хууль;
- Засгийн газрын 2014 оны 06 сарын 25 өдрийн хуралдаанаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны төсвийн хязгаар”;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн төсвийн аргачлал”;
- “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2014 оны 150 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарим анхдагч ангилал батлах тухай” тушаал
- Холбогдох бусад эрх зүйн актууд.

### 1.2 Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтүүд

Улсын Их Хурлын 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг дор дурдсан үндсэн үзүүлэлтүүдээр баталсан.

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2015 он	2016 он	2017 он
1	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ /хувь/	10.2	7.0	5.9
2	Хэрэглээний үнийн индексийн түвшин	7.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	7,201.1	7,322.2	7,793.0
	ДНБ-д эзлэх хувь	29.4	26.5	25.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	7,690.9	7,874.9	8,400.7
	ДНБ-д эзлэх хувь	31.4	28.5	27.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /хувь/	378.5	184.0	525.8
	ДНБ-д эзлэх хувь	1.5	0.7	1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-489.8	-552.7	-607.7
	ДНБ-д эзлэх хувь	-2.0	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,967.3	2,026.3	2,127.7
	ДНБ-д эзлэх хувь	8.0	7.3	7.0
8	Улсын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	9,796.5	11,054.6	12,154.5
	ДНБ-д эзлэх хувь	40.0	40.0	40.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	272.8	285.8	298.8
	ДНБ-д эзлэх хувь	1.1	1.0	1.0

Монгол Улсын Нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийг тооцон гаргахад 2015 онд нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого **7,201.1 тэрбум төгрөг**, нэгдсэн төсвийн нийт зарлага **7,690.9 тэрбум төгрөг**, нэгдсэн төсвийн нийт тэнцэл **-489.8 тэрбум төгрөгийн** алдагдалтай буюу ДНБ-ий **-2.0 хувь** байна.

## 2. Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлогын чиглэлүүд

Дунд хугацаанд макро эдийн засгийн болон төсвийн тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцийг хязгаарлахад чиглэсэн дараах төсвийн бодлогоор тодорхойлогдож байна.

- Төсвийн урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, ДНБ-д эзлэх төсвийн алдагдлын хэмжээг 2.0 хувиас хэтрүүлэхгүй байх;
- УИХ-аас баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдлийг баримтлах;
- Монгол Улсын Их Хурлын “Эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 34 дүгээр тогтоол, Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарт өгсөн чиглэл, зарчмыг удирдлага болгон төсвийн урсгал зардлыг нэмэгдүүлэхгүй байх;
- Цалин, тэтгэврийг тухайн жилийн инфляцийн зорилтот түвшинтэй уялдуулан индексжүүлж нэмэхэд шаардлагатай эх үүсвэрийг төсвийн хязгаарт нэгдсэн байдлаар тусгах;
- Засгийн газраас 2014 онд цалин нэмэгдүүлэхтэй холбоотой гарсан шийдвэрийн дагуу 2015 онд нэмж шаардагдах эх үүсвэрийг тусгах;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн зөвлөмжид “Чингис” үнэт цаас, Хөгжлийн банкны үнэт цаасыг эргэн төлөх хуваарь, эх үүсвэр, зарцуулалтыг тодорхой болгож, улсын төсөвт хэт ачаалал үүсэхээс сэргийлэх зорилгоор 2015, 2016, 2017 оны улсын төсөвт шаардлагатай хөрөнгийг тусгах“ гэж заасны дагуу 2015 оны төсвийн хязгаарт хуримтлал үүсгэх тодорхой хөрөнгийг тусгах

## 3. Монгол Улсын нэгдсэн төсвийн хязгаар

Төсвийн тухай хуулийн 8.3.1-8.3.4 дахь хэсэг, УИХ-аас баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус үндэслэн Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөвт хамаарах төсвийн ерөнхийлөн захирагч нарын багцын 2015 оны төсвийн орлого, зарлагын хязгаарыг Засгийн газрын 2014 оны 6 сарын 25-ны өдрийн 204 дүгээр тогтоолоор батлууллаа.

### 3.1. Улсын болон Нийгмийн даатгалын сангийн төсвийн хязгаар

Төсвийн урсгал зарлагын хязгаарыг тогтоохдоо Улсын Их Хурлын 2014 оны 34 дүгээр тогтоолоор Засгийн газарт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолоор Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус өгсөн чиглэл болон дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, чиглэлд үндэслэн 2014 оны төсвийн тодотголын түвшинг суурь болгон дараах зарчмыг баримтлан тооцсон болно. Үүнд:

1/ УИХ-аас баталсан 2015 оны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийг суурь болгон ашиглаж, төсвийн зарлагын нийт хязгаарыг 2015 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээнд багтаах;

2/ Одоо мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн актанд үндэслэх буюу эрх бүхий байгууллагаар шийдвэр нь эцэслэн батлагдаагүй хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа урсгал зардлыг үндэслэн төсвийн хязгаарыг нэмэгдүүлэхгүй байх;

3/ Засгийн газар, түүний харьяа байгууллагууд болон бүх шатны Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр төрийн албан хаагчдын орон тоог шинээр нэмэгдүүлэхгүй байх, салбарын онцлогоос хамааран гэрээт ажиллагсадын орон тоог 2014 оны тодотголын түвшингээс 50 хувиар бууруулах, ингэснээр орон тооноос хамаарсан цалин, төсвийн бусад урсгал зардлыг бууруулах;

4/ Зөвхөн шинээр ашиглалтад орох барилга, байгууламжийн ашиглалтаас бусад тохиолдолд тавилга эд хогшил худалдан авахгүй байхаар тооцон тавилгын зардлыг 100 хувь бууруулах;

5/ Хуулиар дүрэмт хувцас өмсөхөөр заасан Хил хамгаалах, Цагдаа, Онцгой байдал, Батлан хамгаалах салбар болон Эрүүл мэндийн салбараас бусад салбарт нормын хувцасны зардлыг үе шаттайгаар бууруулах зарчмыг баримтлан 2015 оны төсвийн жилд дээр дурьдсанаас бусад салбар дахь нормын хувцасны зардлыг 50 хувь бууруулах.

6/ Чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогыг харгалзан Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайдын багцаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын гадаад томилолтын зардлыг 2014 оны тодотголын түвшингээс 50 хувиар бууруулах;

7/ Төрийн зарим байгууллага, чиг үүргийг аж ахуйн тооцоонд шилжүүлэх чиглэлээр Засгийн газраас 2014 оны эхний хагас жилд гаргасан шийдвэрүүдийн дагуу зарим төсөвт байгууллагыг 2015 оны төсвийн жилээс эхлэн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар ажиллахаар тооцон орон тоо, урсгал зардлыг бууруулж, харин эдгээр байгууллагаар үйлчлүүлдэг төсөвт байгууллагуудад холбогдох үйлчилгээний тоо хэмжээ, нэгжийн өртгийг үндэслэн шаардагдах урсгал зардлыг тусгав.

8/ Хөдөө орон нутагт ажилласаны тэтгэмж, Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2015 оны төсвийн хязгаарт Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад тооцоогүй болно.

9/ 2014 оны төсвийн жилд хэрэгжих нэг удаагийн шинжтэй хөтөлбөр, арга хэмжээний зардлыг бууруулах;

### **3.2 Орон нутгийн төсвийн хүрээ, хязгаар**

Сангийн сайдын багцад 2015 онд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн хязгаар тусгагдан батлагдсан бөгөөд дээрх нэр төрлийн шилжүүлгүүдийг дараах байдлаар аймгуудад хуваарилахаар урьдчилсан тооцооллыг боловсруулаад байна. Үүнд:

Орлогын шилжүүлэг. ОНХНС-ийн эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан АМНАТ-ын 5 хувийн орлого, дотоодын бараа, ажил, үйлчилгээний НӨАТ-ын 25 хувийн орлого болон ОНХНС-д аймгуудаас төвлөрүүлэх орлогыг тус тус тооцож үзэхэд 2015 онд нийт 316.8 тэрбум төгрөг байхаар байна.

Санхүүгийн дэмжлэг. 2014 оны төсвийн үзүүлэлтийг суурь болгож аймаг, нийслэлд санхүүгийн дэмжлэг болгон нийт 143.2 тэрбум төгрөг олгохоор тооцооллоо.

Тусгай зориулалтын шилжүүлэг. Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан чиг үүрэгтэй холбоотой урсгал зардлыг 56.1.3-т заасан хэлбэрээр олгох хуваариалтын хязгаар 2015 онд 870.2 тэрбум төгрөг байна.

Эдгээр шилжүүлгүүдийн тооцооллыг боловсруулахдаа 2014 оны төсвийн үзүүлэлтүүдэд суурилан боловсруулсан бөгөөд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийн тооцооллыг 2014 оны төсвийн төслийг боловсруулах явцад ашиглаж байсан итгэлцүүрүүд, тоон өгөгдлүүдэд харгалзуулах байдлаар тооцлоо.

Дээр дурдсан шилжүүлгийн хэмжээ, 2015 оны суурь төсвийн тооцооллыг энэхүү удирдамжид заасан орон нутгийн төсвийн санал хянах хугацаанд тодорхой болгох бөгөөд Сангийн сайдын тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 4.4-т заасны дагуу 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор тус яамнаас эдгээр шилжүүлгүүдийн хэмжээ, ашигласан тооцооллын дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг хүргүүлнэ.

Урьдчилсан байдлаар аймаг, нийслэлд дараах шилжүүлгүүдийг олгохоор тооцоод байна:

Хүснэгт. Орон нутагт олгох шилжүүлэг (сая.төгрөг)

АЙМАГ, НИЙСЛЭЛ		САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	ОНХНС-ААС ОЛГОХ ОРЛОГЫН ШИЛЖҮҮЛГИЙН
1	Архангай	11,812.5	13,296.3
2	Баян-Өлгий	10,648.4	11,541.0
3	Баянхонгор	11,332.8	15,444.6
4	Булган	1,514.3	11,178.2
5	Говь-Алтай	8,620.1	15,033.8
6	Дорноговь	0.0	12,269.6
7	Дорнод	4,738.4	13,496.3
8	Дундговь	7,692.4	12,085.1
9	Завхан	10,131.6	12,484.8
10	Өвөрхангай	12,847.1	14,692.5
11	Өмнөговь	0.0	14,775.9
12	Сүхбаатар	7,835.7	12,718.2
13	Сэлэнгэ	2,390.6	10,956.2
14	Төв	9,048.8	11,518.6
15	Увс	9,633.5	12,202.1
16	Ховд	8,375.5	13,258.2
17	Хөвсгөл	17,854.4	14,311.7
18	Хэнтий	8,728.9	12,622.3
19	Дархан-Уул	0.0	10,197.6
20	Улаанбаатар	0.0	52,488.6
21	Орхон	0.0	11,294.9
22	Говь-Сүмбэр	14.3	8,969.4
<b>Нийт дүн</b>		<b>143,219.5</b>	<b>316,835.9</b>

### 3.3 Хүний хөгжил сангийн төсвийн хязгаар

Хүний хөгжил сангийн төсвийн нийт орлогыг 531.5 тэрбум төгрөг, нийт зарлагыг 306.6 тэрбум төгрөг байхаар тогтоолоо. Хүний хөгжил сангийн тухай хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны

хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 2015 онд төр хариуцах иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлд үргэлжлүүлэн 12.0 тэрбум төгрөгийг зарцуулна. Тус сангаас хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжид 240.0 тэрбум төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 54.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулна.

#### **4. Монгол Улсын 2015 оны төсвийн төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл бэлтгэх заавар**

##### **4.1 Төсвийн орлого**

Монгол Улсын 2015 оны төсвийн орлого бүрдүүлэлтэд орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд төсвөөс санхүүжигдэх ажиллагааг хэвийн явуулах эх үүсвэрийг бүрэн бүрдүүлэх бодлого баримтална.

Төсвийн орлогын төлөвлөгөө боловсруулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. УИХ-аас батлагдсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон Засгийн газраас баталсан Төсвийн хязгаарын орлогын доод хэмжээг баримтлах;
2. Төсвийн тухай хуулийн дагуу улсын болон орон нутгийн төсвийн харилцааг бүрэн тусгах;
3. Орлого төлөвлөхөд тухайн орлогын 2014 оны хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцож, 2015 оны төвлөрүүлэх орлогыг өмнөх жилүүдийн ерөнхий хандлага болон тухайн орлогыг бүрдүүлэх суурь үзүүлэлтийн таамаглалд үндэслэх;
4. Төсвийн орлогын төлөвлөлтийг эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн таамаглалтай уялдуулах;
5. Төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий хууль, тогтоомж, бодлогын аливаа шийдвэрийн нөлөөллийг орлогын төлөвлөгөө боловсруулахад тусгах;
6. Уул уурхайн салбараас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа Олон улсад нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас зарласан ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн таамаглал болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдийн үйлдвэрлэл, олборлолтын төлөвлөгөөнд үндэслэн татварын орлогыг бодитой тооцох;
7. Төрийн өмчит компаниудын төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг бууруулахгүй байх;
8. Томоохон төслөөс төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг тооцохдоо төслийн гэрээний онцлог шинжүүдийг авч үзэх, хөрөнгө оруулалттай холбоотойгоор төсөвт орох нэмэгдсэн өртгийн албан татвар, бусад татварын тооцоог нарийвчлан хийж тусгах;
9. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор тус үйл явцын эдийн засгийн үр нөлөөг төсвийн орлогын төлөвлөлтөд тусгах;
10. Олон улсын байгууллага, гадаад орноос Засгийн газрын шугамаар олгож буй буцалтгүй тусламжийн төсөл, арга хэмжээ, бараа, хөрөнгийн орлогыг төсвийн орлогын төлөвлөлтөд бүрэн тусгах.

##### **4.2 Улсын болон НДС-ийн төсвийн зарлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа УИХ-аас баталсан 2015 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд үндэслэн Засгийн газраас баталсан төсвийн зарлагын хязгаарыг баримтлан, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж буй бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр дүнтэйгээр хангахад чиглэгдэнэ.

Урьдчилан төсөөлөх, төлөвлөх боломжгүй бөгөөд УИХ болон Засгийн газраас 2015 оны төсвийн хүрээ, хязгаарыг хэлэлцэн баталснаас хойш үүссэн нөхцөл байдлын улмаас батлагдсан төсвийн хязгаараас давах, зайлшгүй авч үзэх шаардлагатай төсвийн саналыг холбогдох маягтын дагуу төсвийн төслөөс тусад нь бэлтгэж ирүүлнэ.

### **Урсгал зардлын төлөвлөлт**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2015 оны урсгал зардлын хязгаарыг тогтоохдоо 2014 оны тодотгосон төсвийн урсгал зардлаас 2014 онд хэрэгжиж дуусах хөтөлбөр, арга хэмжээний зардлыг бууруулж, хууль эрх зүйн өөрчлөлтийн хүрээнд зайлшгүй шинээр нэмэгдэх арга хэмжээний зардлуудыг нэмж тооцоолсон болно.

### **Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн урсгал зардлын төсөл дараах шаардлага, тооцоо үндэслэлийг хангасан байна:**

1. Урсгал зардлыг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хүрээгээр тодорхойлсон байх;
2. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлэхтэй холбогдуулан төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн төслийг багц бүрээр танилцуулах тул хөтөлбөрт төсвийн танилцуулгад хөтөлбөрийн зорилго, зорилтот түвшин, үндсэн үзүүлэлт, хүрэх үр дүн, түүнийг хэмжих үзүүлэлтийг гаргаж ирүүлэх;
3. Төсвийн төслийг тухай төсвийн жилийн батлагдсан орлого, зарлагын хязгаарт багтаасан байх (Маягт 1б, Маягт 2, Маягт 3, Маягт 4);
4. Жилийн төсвийн хязгаарт багтаагүй саналаа төсвийн төслийн тооцоонд тусгахгүйгээр холбогдох үндэслэл, тайлбарын хамт ирүүлэх (Маягт 1а, Маягт 1в, Маягт 5, Маягт 6, Маягт 7);
5. Эрхлэх асуудлын хүрээнд төсвөөс санхүүжүүлэх тэтгэвэр, тэтгэмж, бусад санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх;
6. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх;
7. Харьяа төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоог ирүүлэх (Маягт 6) ;
8. Шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний тооцоо ( хязгаарт багтсан, эсхүл багтаагүй саналын маягтын аль тохирохоор);
9. Нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй болсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах санал, тооцоог ирүүлэх;
10. 2014 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнгийн гүйцэтгэлийг эхний хагас жилийн болон жилийн эцсийн хүлээгдэж буй байдлаар холбогдох шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн байх;
11. Төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоог ирүүлэх;
12. Төсвийг хэрэгжүүлэхэд шаардагдах орц, төсөв, санхүүжүүлэх эх үүсвэр, хүрэх үр дүнг хөтөлбөрөөр болон эдийн засгийн ангиллаар илэрхийлсэн зарлагын хуваарилалтын тооцоо ( хязгаарт багтсан, эсхүл багтаагүй саналын маягтын аль тохирохоор);
13. Ажлын ачааллыг нягтруулах замаар одоо мөрдөгдөж байгаа орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим баримтлаж, орон тоо, цалингийн санг төлөвлөх;
14. Бараа үйлчилгээний үнэ тарифын өсөлтийг 2014 оны түвшинд, цалин, тэтгэвэр тэтгэмжийн өсөлтийг тэгтэй тэнцүү байхаар тооцож ирүүлэх;
15. Өмнөх жилүүдийн хөрөнгө оруулалтын төслийн үр дүнд 2015-2017 онуудад шинээр ашиглалтад орж буй барилга, байгууламжийн ашиглалтын зардал, орон тоо, цалин хөлсний зардал, санхүүжүүлэх эх үүсвэрийн тооцоог тусад нь боловсруулж ирүүлэх;



16. Олон улсын байгууллага, гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр салбарын хэмжээнд хэрэгжиж буй болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн орлого, зарлагын тооцоог нэгтгэн ирүүлэх.

**Төсвийн урсгал зардлыг төлөвлөхөд дараах зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй байна. Үүнд:**

1/ Төсвийн зарлагын “үндсэн цалин” гэсэн эдийн засгийн ангилалд зөвхөн Засгийн газрын тогтоолоор батлагдсан цалингийн сүлжээгээр олгогдох цалин хөлсийг, “нэмэгдэл” гэсэн эдийн засгийн ангилалд зөвхөн хууль, Засгийн газрын тогтоолын дагуу үндсэн цалингаас бодогдож буй нэмэгдлийн хэмжээг, унаа хоолны хөнгөлөлт гэсэн ангилалд албан хаагчдад олгож буй унаа, хоолны хөнгөлөлтийг, “урамшуулал” гэсэн эдийн засгийн ангилалд зөвхөн тухайн албан хаагчдад олгож буй үр дүнгийн урамшууллын хэмжээг, “гэрээт ажлын цалин” гэсэн эдийн засгийн ангилалд зөвхөн гэрээт ажилчдын цалингийн хэмжээг тус тус хамааруулах.

2/ Автомашин ашиглалтын болон тээвэр шатахууны зардлыг төлөвлөхдөө Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолоор баталсаны дагуу албан тушаалын, албан ажлын болон дуудлагын автомашины нормативыг үндэслэн төлөвлөх. Жишээлбэл, Яамны хэрэгцээнд албан тушаалын автомашиныг зөвхөн Сайд, албан ажлын автомашиныг яамны дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар хэрэглэх бол бусад ажиллагсадын дунд ажлын онцлогоос хамааран дуудлагын автомашин үйлчилэхээр тооцон тээвэр, шатахууны зардлыг төлөвлөх.

3/ Төсвийн ерөнхийлөн захирагч нар харьяалах салбар бүрт хэрэгжиж буй хөтөлбөр, арга хэмжээ болон бүтэц зохион байгуулалтыг УИХ-ын 2014 оны 34 тогтоол, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолоор гаргасан чиглэлийн дагуу хянан үзэж үр ашгийг нэмэгдүүлэх, цомхон оновчтой болгох замаар зардлыг хэмнэх ба аливаа хэмнэгдсэн зардлаар тухайн салбарт шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх зарчим баримтлах;

4/ Төсвийн тухай хуулийн дагуу аливаа байгууллага нь төсвийн шууд захирагчид хамаарах тул тухайн салбарын “Төвлөрсөн арга хэмжээ” гэдэг байгууллагыг 2015 оны төсвийн жилээс эхлэн төсвийн төлөвлөлтөд ашиглахгүй болно. Жишээлбэл, боловсролын төвлөрсөн арга хэмжээ, нийгмийн хамгааллын төвлөрсөн арга хэмжээ, хөдөлмөрийн төвлөрсөн арга хэмжээ, Байгаль орчны төвлөрсөн арга хэмжээ, Эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээ, Спортын төвлөрсөн зардал гэх мэт. Иймд дээрх “...төвлөрсөн арга хэмжээ” -нд хамаарч байсан урсгал зардлыг бууруулах, зарим шаардлагатай зардлыг түүний хэрэгжилтийг нэгтгэн хариуцаж буй холбогдох төсвийн шууд захирагчийн төсөвт тусган төлөвлөх;

5/ Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал дахь “Төвлөрсөн арга хэмжээний зардал”-аас “цалин хөлс, гадаад дотоод томилолт, тэтгэмж, урамшуулал” зэрэг төрөл бүрийн зардал гарах хандлагатай байна. Иймд 2015 оны төсвийн жилээс эхлэн “төвлөрсөн арга хэмжээ” гэсэн зардлын зүйлээр аливаа зардлыг төлөвлөхгүй байхаар төсвийн зарлагын ангиллыг шинэчилсэн болно. Иймд “төвлөрсөн арга хэмжээ”, “төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ”-ний зардлын ангиллыг түүнийг нэгтгэн зохион байгуулах байгууллага /яам, эсвэл агентлаг, ЗДТГ г.м/-ын төсөвт зардлын хөтөлбөр, арга хэмжээ, зориулалт болон эдийн засгийн ангиллаар төлөвлөх;

6/ Засгийн газрын тусгай сангаас хэрэгжүүлэх аливаа арга хэмжээний аль нэг эдийн засгийн ангилалд бөөн дүнгээр төлөвлөсөн зардлыг зохих хөтөлбөр, арга хэмжээ-зориулалт, эдийн засгийн ангиллаар нь задалж төсөвт тусгах. Жишээлбэл, Аялал жуулчлалын сан, Монгол судлалыг хөгжүүлэх санг хөтөлбөр, арга хэмжээ эдийн засгийн ангилал, зориулалтаар нь задалж төлөвлөх;

7/ Хөдөө орон нутагт ажилласан тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 2015 оны төсвийн хязгаарт Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад тооцоогүй. Иймд Төсвийн ерөнхийлөн захирагч нар тэтгэвэрт гарах хүн, хөдөө орон нутагт ажилласан тэтгэмж авах хүний судалгааг хүн тус бүрээр нарийвчлан гаргасны үндсэн дээр төсвийн төсөлд тооцож ирүүлэх.

#### 4.3.1 Төв болон орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгүүд

2015 онд орон нутгийн төсөвт Төсвийн тухай хуулийн 56.1.1, 56.1.2-т заасны дагуу олгох санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн тооцооллыг Сангийн яам энэхүү удирдамжид заасан орон нутгийн төсөв хянах хуваарьт хугацаанд аймаг, нийслэл нэг бүртэй хэлэлцэн тогтооно.

#### 4.3.2. Тусгай зориулалтын шилжүүлгийн хуваарилалтын санал бэлтгэх

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасан чиг үүрэгтэй холбоотой зардлыг 56.1.3-т заасан хэлбэрээр олгох хуваарилалтын хязгаарыг холбогдох улсын төсвийн ерөнхийлөн захирагч 7 дугаар сарын 10-ны дотор орон нутаг дахь холбогдох агентлагаар дамжуулж орон нутаг дахь улсын төсвийн байгууллагад хүргүүлнэ.

Орон нутаг дахь улсын төсвийн байгууллага тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийг боловсруулж сум, дүүргийн Засаг даргад 7 дугаар сарын 20-ны дотор, сум, дүүргийн Засаг дарга урсгал төсвийн саналыг хянан баталгаажуулж аймаг, нийслэлийн Засаг даргад 7 дугаар сарын 25-ны дотор тус тус хүргүүлнэ.

Аймаг, нийслэлийн Засаг дарга тусгай зориулалтын саналыг хянан баталгаажуулж 8 дугаар сарын 01-ны дотор улсын төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн Засаг даргын харьяа холбогдох агентлаг Засаг даргад тусгай зориулалтын шилжүүлгийн хуваарилалтын санал боловсруулахад мэргэжил, арга зүйн үйлчилгээ үзүүлж ажиллана.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн саналыг холбогдох улсын төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдамжид заасан маягтын дагуу нэгтгэн 8 дугаар сарын 15-ны дотор Сангийн яаманд ирүүлнэ.

## 5. Бусад нэмэлт мэдээллүүд

### 5.1 Төсвийн ангилал ашиглах

Монгол Улсын 2015 оны төсвийн саналыг Сангийн яамны FISCAL 5.4 програмд ашиглаж байгаа 1/ эдийн засгийн зардлын 2/ байгууллагын 3/ хөтөлбөрийн 4/ зориулалтын буюу арга хэмжээний 5/санхүүжүүлэх эх үүсвэрийн ангилалын дагуу бэлтгэнэ.

Төсвийн маягтыг бөглөхдөө холбогдох ангиллын кодыг оруулсан байна. Хэрэв шинээр бий болсон арга хэмжээтэй холбоотой ангиллын зүйл өгөгдсөн санд байхгүй бол шинээр оруулж холбогдох тайлбарыг бичнэ. Төсвийн хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангиллууд болон холбогдох маягтуудыг энэхүү удирдамжид хавсаргаагүй бөгөөд та бүхэн төсвийн ил тод байдлын тухай [www.iltod.gov.mn](http://www.iltod.gov.mn) цахим хуудсаас 2014 оны 7-р сарын 21-ний өдрийн дотор тавигдах болно.

## 5.2 Бусад

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн саналаа бэлтгэхдээ төсвийн маягтад заасан үзүүлэлтийг бүрэн бөглөх ба мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцна.

Төсвийн маягтуудад тусгах саналын мөнгөн илэрхийллийг мянгатын орноор нарийвчлана.

## 5.3 Төсвийн санал хүлээн авч хянах хугацаа

Улсын төсөв, НДС-ийн төсөв, ХХС-ийн төсөв болон орон нутгийн төсөвт хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг дор дурдсан хугацаанд хянана:

- Орон нутгийн төсвийн төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсөвт байгууллагуудын саналыг дор дурдсан цаглабараар хэлэлцүүлэг хийж төсвийн төслийг хянана:

Д/Д	АЙМГИЙН НЭР	Эхлэх огноо	Дуусах огноо
1	Архангай	2014.08.04	2014.08.06
2	Баян-Өлгий	2014.08.04	2014.08.06
3	Баянхонгор	2014.08.04	2014.08.06
4	Булган	2014.08.04	2014.08.06
5	Говь-Алтай	2014.08.04	2014.08.06
6	Дорноговь	2014.08.06	2014.08.08
7	Дорнод	2014.08.06	2014.08.08
8	Дундговь	2014.08.06	2014.08.08
9	Завхан	2014.08.06	2014.08.08
10	Өвөрхангай	2014.08.06	2014.08.08
11	Өмнөговь	2014.08.11	2014.08.13
12	Сэлэнгэ	2014.08.11	2014.08.13
13	Төв	2014.08.11	2014.08.13
14	Увс	2014.08.11	2014.08.13
15	Ховд	2014.08.11	2014.08.13
16	Сүхбаатар	2014.08.13	2014.08.15
17	Хөвсгөл	2014.08.13	2014.08.15
18	Хэнтий	2014.08.13	2014.08.15
19	Дархан-Уул	2014.08.13	2014.08.15
20	Говьсүмбэр	2014.08.13	2014.08.15
21	Орхон	2014.08.13	2014.08.15
22	Улаанбаатар	2014.08.18	2014.08.22

- Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийн саналыг харъяалах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.
- 8 дугаар сарын 11-ны өдрөөс 8 дүгээр сарын 30-ны хооронд Сангийн яам улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийг хянаж дууссан байна.
- 9 дүгээр сарын 02-наас 9 дүгээр сарын 10-ны хооронд Сангийн яам төсвийн төсөлд инфляцийн болон бусад бодлогын тохируулгыг хийж дууссан байна.

Сангийн яамнаас Засгийн газарт Монгол Улсын 2015 оны төсвийн төсөл, Хүнийн хөгжил сангийн 2015 оны төсвийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн төслийг холбогдох бусад материалын хамт 2014 оны 09 дүгээр сарын 11-нд өргөн мэдүүлнэ.

**Тэмдэглэл:**

Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн саналыг Төрийн сангийн сүлжээнд байршуулсан Fiscal 5.5 программ хангамжийн тусламжтай авна. Энэ нэг талаас ирээд шивж оруулдаг хугацааг багасгах ач холбогдолтой болно.

Саналыг оруулахдаа **2015 он** сонгоод **өгөгдөл цэсний төлөвлөлт зарлага, төлөвлөлт орлого** хэсгүүдэд **2013 оны гүйцэтгэл, 2014 оны ХБГ, 2015 оны санал, 2016 оны төсөөлөл, 2017 оны төсөөлөл** багануудыг бүх аймаг, нийслэлийн хэрэглэгчдэд нээсэн байгаа.

Тоон өгөгдлийг төсөв хянуулж эхлэхээс өмнө буюу 2014 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн дотор гүйцэд оруулж дуусгахыг анхаарах шаардлагатай.

## **6. Төсвийн төсөл бэлтгэх маягтууд, тэдгээрийн заавар**

Төсвийн төсөл бэлтгэх маягтууд нь 1/ Үндсэн маягтууд, 2/ Нэмэлт маягтууд, 3/Хавсралт маягтууд гэсэн 3 хэсгээс бүрдэх бөгөөд тоон өгөгдөл, төсвийн ангиллын код, текстэн мэдээллийг оруулна. Хэрэв мэдээлэл өгөгдсөн хэмжээнд багтахгүй тохиолдолд мэдээний талбарыг өргөтгөж болно. Төсвийн ангиллыг холбогдох маягтуудад тусгахдаа ангиллын кодыг заавал хамт оруулсан байна.

### **6.1 Үндсэн маягтууд**

#### ***Маягт 1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналын товчоо:***

Энэхүү маягт нь ***Ерөнхий мэдээллийн хэсэг, Маягт 1а, Маягт 1б, Маягт 1в*** гэсэн дөрвөн хэсгээс бүрдэх бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн үндсэн мэдээллийг оруулна. 1б хэсэг нь заавал бөглөх хэсгийн нэгтгэл товчоо бөгөөд 1а, 1в хэсгүүд нь зөвхөн төсвийн хязгаараас давсан саналын нэгтгэл товчоо байдлаар ашиглах нэмэлт хэсэг болно.

- ***Ерөнхий мэдээллийн хэсэг.*** Энэ хэсэгт төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр, код, 2014 оны төсвийн багцын ХБГ, 2015 оны төсвийн хязгаар болон эдгээрийн хоорондын зөрүүний тухай үндсэн мэдээллийг оруулсан байна. Түүнчлэн энэ хэсэгт салбарын нийт орон тоог төрийн албан хаагчийн ангиллын дагуу оруулж өгсөн байх шаардлагатай. Энэ хэсэгт тодорхойлсон зарим үндсэн мэдээлэл бусад маягтын эхэн хэсэгт нэгэн адил давтагдана.
- ***1б. Төсвийн зарлагын хязгаарт багтсан төсөвлөлтийн мэдэгдлийн товчоо.*** Төсвийн зарлагын хязгаарт багтсан хөтөлбөрүүдийн төсвийн зарлагын төлөвлөлтийн мэдэгдлийн нэгтгэл байна. Нэгтгэлийн хүснэгтийг зарлагын эдийн засгийн ангиллын 4 болон 5 дугаар шатлалаар харуулсан байна. Шаардлагатай нэмэлт тайлбарыг нэгтгэлийн хүснэгтийн дор тодорхойлж болно. Төсвийн тоон үзүүлэлтүүдийг 2014 оны ХБГ болон 2015 оны төсвийн төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл байдлаар тооцож харуулна.

**Маягт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөтөлбөрийн мэдэгдэл:**

Энэ хэсэгт одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрийн талаарх мэдээллийг хөтөлбөр бүрээр харуулна. Хөтөлбөрийн тодорхойлолт хэсэгт тухайн хөтөлбөрийн хамрах хүрээ, бүрэлдэхүүн, зориулалтыг товч тодорхойлсон байна. Хэрэв одоо хэрэгжиж байгаа хөтөлбөр, арга хэмжээнд (голдуу тоон үзүүлэлт) өөрчлөлт орсон бөгөөд тэдгээр нь төсвийн зарлагын хязгаараас хэтрэхгүй бол энэ маягтад тусган тайлбарлана.

**Маягт 3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн зарлагын төлөвлөлтийн мэдэгдэл:**

**Маягт 2**-г тодорхойлсон хөтөлбөрийн мэдэгдлийн хүрээнд тавигдсан зорилтыг хангахад шаардагдах санхүүжилтийн хэрэгцээг энэ хэсэгт тодорхойлно. Зарлагын төлөвлөлтийн мэдэгдлийг хөтөлбөр нэг бүрээр тодорхойлох шаардлагатай ба эдгээр нь **Маягт 1б**-д нэгтгэгдэнэ. Хөтөлбөрийн санхүүжилтийн хэрэгцээт зардлыг эдийн засгийн ангиллын хамгийн доод шатлалын түвшинд оруулна. Түүнчлэн санхүүжилтийн эх үүсвэрийг эдийн засгийн ангиллаас сонгон тусад нь харуулсан байх шаардлагатай

**Маягт 4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Хөтөлбөрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт:**

Энэ маягтаар жилийн эцэст төсвийн хөрөнгөөр хөтөлбөрийн зорилтыг хэрхэн хангасан байх тухай амлалтыг урьдчилан тооцож харуулна. Хүрэх үр дүнг тодорхойлохдоо хэт ерөнхий, бүрхэг байдлаар тодорхойлохоос зайлсхийж, хэмжигдэхүйц, биелэгдэхүйц, бодитой, хугацаатай үзүүлэлтийг тодорхойлно. Тухайн хөтөлбөрийн хамрах цар хүрээ, онцлогоос хамаарч гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн түвшинд ерөнхий эсхүл бүтээгдэхүүн арга хэмжээ, төсөл бүрээр нарийвчлан тодорхойлж болох ба эдгээр нь хөтөлбөрийн зорилгыг хангах ахиц дэвшлийг хэмжихэд хэрэглэх боломжтой тоон утгаар илэрхийлэгдсэн байна.

## 6.2 Нэмэлт маягтууд

**Маягт 5, Маягт 6, Маягт 7 : Төсвийн хязгаараас давсан санал бэлтгэх:**

Нэмэлт санхүүжилтийн хүснэгтүүд болох **Маягт 5, Маягт 6, Маягт 7** нь бүтцийн хувьд заавал дагаж мөрдөх маягт (**Маягт 1, Маягт 2, Маягт 3**)-тай ижил бөгөөд гагцхүү нэмэлт санхүүжилтийн хэрэгцээ гарч төсвийн зарлагын хязгаараас давах тохиолдолд энэхүү маягтуудыг бэлтгэнэ. Нэмэлт маягтуудыг хөтөлбөр нэг бүрээр гаргах ба эдгээрт тусгасан техтэн болон тоон мэдээллүүд **Маягт 1а, Маягт 1в**-д нэгтгэгдэнэ. Эдгээр маягтууд нь хамтдаа нэгтгэгдэн тухайн шийдвэрлэх асуудлын талаарх цогц мэдээллийг шийдвэр гаргах түвшинд хүргэх зорилготой бөгөөд зөвхөн төсвийн нөөц гарсан тохиолдолд нэмэлт санхүүжилтийг хуваарилахад мэдээлэл болгон ашиглана. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр арга хэмжээнүүдийг хэрхэн шийдвэрлэх талаарх тайлбарыг маягт бүрийн тайлбар хэсэгт тодорхойлно. Төсвийн ерөнхийлөн захирагч нь эдгээр нэмэлт маягтуудыг бөглөх тохиолдолд заавал дагаж мөрдөх маягтуудыг хамт бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтуудаар ирүүлсэн нэмэлт санхүүжилтийн талаарх хүсэлт нь заавал дагаж мөрдөх маягтуудад тусгасан санхүүжилтийн хүсэлтийн дүнд багтаагүй байх шаардлагатай.

## 6.3 Хавсралт маягтууд

Хавсралт маягтууд нь үндсэн болон нэмэлт маягтуудад оруулсан мэдээллийг нарийвчлан хянах, өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх зорилгоор бэлтгэгдсэн ба байгууллага эдгээр маягтуудыг заавал бөглөнө.

**Маягт 8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяалах төсвийн байгууллагын өөрийн орлого**

Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлогын тооцооллыг нөлөөлөгч хүчин зүйлсээр тодорхойлж харуулна. Хэрэв хүчин зүйлс нь бодлогын шийдвэрээр баталгаажсан бол холбогдох шийдвэрийн нэр, дугаар, огноог маягтын доод хэсэгт байрлах нэмэлт хүснэгтэд тодорхойлж харуулсан байна.

**Маягт 9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн урсгал зардлын саналын товчоо**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн урсгал зардлын хэмжээг өөрчлөхөд нөлөөлсөн хүчин зүйлсийг маягтын холбогдох багануудад тодорхойлсон ба эдгээрийг зардлын эдийн засгийн ангилалын зүйлсийн аль тохирох мөрөнд харгалзуулан бөглөнө. Хэрэв зардлын өөрчлөлтөд нөлөөлсөн хүчин зүйлс нь бодлогын шийдвэрээр баталгаажсан бол холбогдох шийдвэрийн нэр, дугаар, огноог маягтын доод хэсэгт байрлах нэмэлт хүснэгтэд тодорхойлж харуулсан байна. Орон нутгийн төсвийн байгууллагын хувьд 2014 оны ХБГ нь 2015 оны төсвийн хязгаар нь болно.

**Маягт 10. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн санал**

Энэ маягтаар төсвийн ерөнхийлөн захирагчийн дамжуулан зээл/гадаад, дотоод/түүний авлагын барагдуулалт, хувьцаа болон дүрмийн сангийн бүрдүүлэлт, төсвийн зээлийн мэдээллийг холбогдох баганад харгалзах хүчин зүйлсээр тодорхойлж харуулна. Хэрэв хүчин зүйлс нь бодлогын шийдвэрээр баталгаажсан бол холбогдох шийдвэрийн нэр, дугаар, огноог маягтын доод хэсэгт байрлах нэмэлт хүснэгтэд тодорхойлж харуулсан байна.

**Маягт 11. Шинэ хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээтэй холбоотой урсгал зардлын тооцоо**

Шинэ хөрөнгө оруулалтыг дагаж гарах урсгал зардлыг холбогдох жилүүдээр тооцож “А” хэсэгт харуулна. Нэг жилд хэдий хир хэмжээний урсгал зардал шаардагдахыг маягтын 5 дугаар баганад хөрөнгө оруулалтыг ашиглалт орсоноос хойшхи цэвэр 12 сараар тооцож харуулна. Хэрэгцээт орон тооны хүсэлтийг “Б” хэсэгт харуулна. Хэрэв одоогийн ажиллаж байгаа орон тоог шилжүүлэхээр бол цэвэр нэмэгдэх орон тоог тусад нь харуулна. Жишээ нь шинээр ашиглах орох сургуульд нийт 11 орон тоо шаардлагатай ба үүний 5 орон тоог одоо ажиллаж байгаа сургуулиас шилжүүлнэ гэвэл цэвэр нэмэгдэх орон тоо нь 1 байна гэх мэт.

**Маягт 12. Төр хариуцах эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн тооцоо**

Хүний хөгжил сангийн төсөвтэй холбоотой мэдээллийг энэ хүснэгтэд оруулна

**Маягт 13. Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлт тусламжийн төрөл**

Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцохдоо энэ хүснэгтэд заагдсан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйчилгээний төрөл, нэг хүнд ногдох тэтгэмж тусламж, үйлчилгээний хэмжээг ашиглана.

---o0o---